

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2023/08

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2023.VIII	2022.VIII	2023.VII	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 2-р улирал	их наяд ₮, оны үнээр	30.4	23.1	-	-	-	-	6.4% ▲
Инфляц	хувь	10	14.4	9.2	-0.2% ▼	-	6.6% ▲	-4.4 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин, 2023У2	хувь	5.8% 2023 оны У2	7.8% 2022 оны У2	5.8% 2023 оны У2	-	-0.8% ▼ нэгж хувиар	-	-2.0% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1818	-900	1360	458 ▲	-	-	2718 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3469.98	3185.70	3442.35	27.63 ▲	-	-	284.28 ▲
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	4057.0	2156.0	3674.7	382 ▲	-	-	1901 ▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	42.6	14.9	35.4	22% ▲	-	-	2.8 дахин ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	1022.3	976.8	891.3	3% ▲	-	-	5% ▼
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	10%	13%	0%	-	0%	3% ▲
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	3.93	2.69	3.83	3% ▲	-	-	46% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	8.59%	11.3%	8.77%	-0.18 нэгж хувиар ▼	-	-	-2.44 нэгж хувиар ▼

ОНЦЛОХ СТАТИСТИК:

2023 оны эхний хагаст ДНБ 6.4%-иар өсөв	ДНБ, 2023 оны эхний хагас жилд 6.4 хувиар өссөний -1.7 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар, 3.9 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 0.3 нэгж хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 3.5 нэгж хувийг үйлчилгээний салбар, 0.4 нэгж хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар бүрдүүлсэн байна.
Монгол Улсын гадаад валютын албан нөөц 46%-иар нэмэгдэв	Манай улсын гадаад валютын улсын нөөц 2023 оны долдугаар сард 3.93 тэрбум ам.доллар болжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 46 хувиар нэмэгджээ.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлд	2023/9/15	2024 онд инфляцыг 6+/-2 хувийн интервалд барих буюу эдийн засгийн хувьд хэвийн үеийн инфляцын зорилт руугаа шилжиж байна. Бодлогын хүүг 13% хэвээр үлдээлээ.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График

Нөлөөлөл

Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 10.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 16.4 хувь нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 18.0 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 16.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.2 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.9 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Валютын ханш




Америк долларын ханш 2023 оны 8 дугаар сард 3469.98 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 284.28 төгрөгөөр, өмнөх сараас 27.63 төгрөгөөр суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 3%-иар, өнгөрсөн жилийн мөн үеэс 46%-иар тус тус өсөж, 3.93 тэрбум ам.долларт хүрээд байна.

Улсын төсөв



Татварын нийт орлого 2023 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 13.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.4 (47.1%) их наяд төгрөгөөр өсөхөд орлогын албан татварын орлого 1.7 (82.9%) их наяд төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны татвар 1.4 (2.4 дахин) их наяд нийгмийн даатгалын орлого 537.8 (29.0%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 472.4 (19.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин онцгой албан татвар 80.8 (13.3%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Гадаад худалдаа



Монгол Улс 2023 оны эхний 8 сард нийт 155 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 16.0 тэрбум америк доллар, үүнээс экспорт 10.0 тэрбум америк доллар, импорт 5.9 тэрбум америк доллар байна. 2023 оны эхний 8 сард экспорт өмнөх оны мөн үеэс 2.3 тэрбум америк доллароор өсөхөд нүүрс 2.0 тэрбум америк доллароор, газрын тос 135.1 сая америк доллароор, жоншны хүдэр ба баяжмал 96.9 сая америк доллароор, лаазалсан махан бүтээгдэхүүн 91.5 сая америк доллароор, адууны мах 66.3 сая америк доллароор, төмрийн хүдэр, баяжмал 30.5 сая америк доллароор тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Дэлхийн эдийн засагт

- Дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд 3.4 хувь байсан бол өсөлт 2023 онд 2.8 хувь болж буурч, 2024 онд 3.0 хувьд хүрэх төлөвтэй байна.

Эх сурвалж: Олон улсын валютын сан

- Инфляц бүс нутгийн хэмжээнд 2023 онд 4.2%, 2024 онд 3.3% буурах төлөвтэй байгаа N⁰

Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, <https://ikon.mn/n/2tv5>

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 8-р сар 2023 он, Үндэсний статистикийн хороо](#)

2. [Статистикийн бюллетень, 8-р сар 2023 он, Монголбанк](#)

3. www.1212.mn, www.mongolbank.mn